



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар A/835

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ковид 19 цар тахлын үед хөл хорио тогтоосонтой холбогдуулан нэн эмзэг бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд амин дэм болон хүнсний тусламж, дэмжлэг үзүүлэх зардалд 4 000 000 төгрөг зарцуулсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 4 000 000 /Дөрвөн сая / төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний 5.19-д тусгагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих” арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

